

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2022 оны 06 дүгээр сарын
09-ны өдөр

Дугаар 1158 1/340

Улаанбаатар хот

Багшийн эрүүл мэндийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны "Багшийн хөгжлийг дэмжих талаар авах арга хэмжээний тухай" 145 дугаар тогтоолын 3 дахь хэсгийг үндэслэн, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нарын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор ТУШААХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг хамруулах "Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгооны жагсаалт"-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Багш нарыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулахтай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт үүрэг болгосугай.
 - 2.1 Багш нарыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгоонд хавсралтад заасан хугацааны дагуу хамруулах;
 - 2.2 Багш нарын урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгоог магадлан итгэмжлэгдсэн төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, төлбөрийг зохих журмын дагуу санхүүжүүлж, тайлагнах;
 - 2.3 Боловсролын салбарын мэдээллийн системд багш нарын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгоонд хамрагдсан талаарх мэдээллийг бүртгэх ажлыг зохион байгуулах.
3. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нарт урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгоо хийх Эрүүл мэндийн байгууллагын удирдлагуудад дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай.
 - 3.1 Багш нарын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгоог зохион байгуулахдаа цэцэрлэг, сургуулийн удирдлагатай байгуулсан гэрээний дагуу төлөвлөж, чанартай зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд нарийвчилсан оношилгоо, эмчилгээний талаар зөвлөгөө өгч, дараагийн шатлалын эрүүл мэндийн байгууллагад илгээх;
 - 3.2 Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгооны нэгдсэн дүн, мэдээллээр сургалтын байгууллагын удирдлагыг хангах.
4. Багшийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг оношилгооны мэдээллийг салбар хооронд системээр дамжуулан солилцох ажлыг судалж, хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны яамны Цахим бодлого, статистикийн

хэлтэс (Ю.Алтантуяа), Эрүүл мэндийн яамны Судалгаа, төлөвлөлтийн хэлтэс (Э.Оюунсүрэн)-т тус тус үүрэг болгосугай.

5. Багшийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг оношилгоонд 2022 онд шаардагдах 1,883,855.0 (нэг тэрбум найман зуун наян гурван сая найман зуун тавин таван мянга) төгрөгийг төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд нэг хүүхдэд ноогдох хувьсах зардлын дундаж нормативын дагуу хуваарилж санхүүжүүлэхийг Боловсролын ерөнхий газар /Т.Ням-Очир/-т зөвшөөрсүгэй.

6. "Багшийн эрүүл мэнд" арга хэмжээний төслийг 2022 оны 7 дугаар сард багтаан боловсруулж танилцуулахыг Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газар /Ж.Ганбаатар/-т даалгасугай.

7. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах ажлыг удирдлагаар хангаж ажиллах, нэгдсэн тайланг Боловсрол, шинжлэх ухааны сайдын шуурхай хуралдаанд 2023 оны 1 дүгээр улиралд багтаан танилцуулахыг Боловсролын ерөнхий газар /Т.Ням-Очир/, Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газар /Д.Баярболд/-т тус тус үүрэг болгосугай.

8. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга /Л.Цэдэвсүрэн/, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Ц.Эрдэмбилэг/ нарт тус тус даалгасугай.



Боловсрол, шинжлэх ухааны сайд,
 Эрүүл мэндийн сайдын 2022 оны 06 дүгээр
 сарын 29.....өдрийн 1038 № дугаар хамтарсан
 тушаалын хавсралт

ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГШ НАРЫГ
 ХАМРУУЛАХ НЭМЭЛТ ҮЗЛЭГ, ОНОШИЛГООНЫ ЖАГСААЛТ

№	Багш	Үзлэг, оношилгоо			
		Цагаан хорхой	Хелико-бактери	Дууны хөвчийн дуран 40-өөс дээш нас, 3 жил тутам	Бамбайн даавар (TSH буюу ТТГ) 2 жил тутам
1	Цэцэрлэгийн багш	+	+	+	+
2	Цэцэрлэгийн туслах багш	+	+	+	+
3	Цэцэрлэгийн арга зүйч	+	+	-	+
4	Цэцэрлэгийн эрхлэгч	+	+	-	+
5	Багаангийн багш	+	+	+	+
6	Дотуур байрын багш	+	+	+	+
7	ЕБС-ийн бусад багш	-	+	+	+

---оо---